



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн  
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2024/78/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг

2024 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр

Утас:70373089, 99023682

Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер: У.Батсүрэн

Утас:99023682

Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас:99377479

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК

Захирал: Б.Жаргалсайхан

Утас:99862066

Цахим хаяг:peakomaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

*Дархан-Уул* № *76*

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дархан-Уул аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 40,551.6 мянган төгрөгийн хууль тогтоомж, холбогдох тушаал шийдвэрийг биелүүлж ажилаагүй, ажил гүйлгээг бүртгэхдээ НБББББ-ыг мөрдөөгүй зэрэг зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, СНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 6 сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд, ерөнхий боловсролын сургуулиудад сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг хуваарилах, зарцуулахыг талаар чиглэл өгсөн байна.

Дархан-Уул аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний нийт төсвийн гүйцэтгэл 92.19 хувийн биелэлттэй байна.

### **Аудитын гол асуудал**

Засгийн Газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240, 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоож, Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/109 тоот тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн урамшуулалд нийт багш, ажилчдыг хамруулан олгохоор шийдвэрлэсэн байна

### **Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 19 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг БШУГ-ын даргын 2024 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 тоот тушаалаар 85 хувиар биелүүлсэн гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>88,721,974.79</b>	<b>154,996,733.08</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>39,640,473.41</b>	<b>102,825,481.70</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>39,640,473.41</b>	<b>102,825,481.70</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>39,640,473.41</b>	<b>102,825,481.70</b>
31211	Төрийн сангийн харилцах	39,640,473.41	102,825,481.70
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>281,550.00</b>	<b>0.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>281,550.00</b>	<b>0.00</b>
33520	Хувь хүмүүсээс авах авлага	281,550.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>48,799,951.38</b>	<b>52,171,251.38</b>
35130	Эм боох материал	860,700.00	860,700.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>47,939,251.38</b>	<b>51,310,551.38</b>
35410	Бичиг хэргийн материал	2,109,000.00	2,300,300.00
35420	Аж ахуйн материал	2,454,200.00	2,199,800.00
35460	Хүнсний материал	141,800.00	3,576,200.00
35470	Бусад хангамжийн материал	43,234,251.38	43,234,251.38
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,039,501,299.83</b>	<b>1,168,877,444.12</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,039,501,299.83</b>	<b>1,168,877,444.12</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>996,841,350.81</b>	<b>1,126,329,925.14</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,076,621,060.00	1,076,621,060.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(265,831,848.93)	(283,775,533.29)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	190,293,084.96	359,144,767.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	(57,917,593.95)	(107,045,307.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,410,437.00	82,397,572.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(41,896,571.17)	(45,992,881.55)
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,347,696.80)	(9,446,922.72)
39217	Ном	33,220,619.70	39,137,310.68
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>42,659,949.02</b>	<b>42,547,518.98</b>
39302	Хуримтлагдсан элэгдэл	(440,350.98)	(552,781.02)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,128,223,274.62</b>	<b>1,323,874,177.20</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,128,223,274.62</b>	<b>1,323,874,177.20</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,128,223,274.62</b>	<b>1,323,874,177.20</b>
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	270,560,830.28	270,560,830.28
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(127,179,890.54)</b>	<b>68,471,012.04</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,255,403,165.16)	(127,179,890.54)
51220	Тайлант үеийн үр дүн	1,128,223,274.62	195,650,902.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	984,842,334.88	984,842,334.88
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,128,223,274.62</b>	<b>1,323,874,177.20</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,196,478,931.31</b>	<b>1,522,076,170.41</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,108,354,331.31</b>	<b>188,559,970.41</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,108,354,331.31</b>	<b>188,559,970.41</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>6,098,486.00</b>	<b>1,217,148.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,193,400.00	1,066,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,905,086.00	150,648.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,042,113,271.15	172,120,675.41
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	60,142,574.16	15,222,147.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,088,124,600.00</b>	<b>1,333,516,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>887,673,800.00</b>	<b>1,145,082,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	887,673,800.00	1,145,082,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>200,450,800.00</b>	<b>188,433,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	200,450,800.00	188,433,800.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,068,255,656.69</b>	<b>1,326,425,267.83</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,068,255,656.69</b>	<b>1,326,425,267.83</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,005,685,493.37</b>	<b>1,275,003,383.46</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>649,356,136.57</b>	<b>833,949,779.43</b>
210101	Үндсэн цалин	448,492,551.37	598,637,591.08
210102	Нэмэгдэл	143,923,032.38	202,723,931.35
210104	Урамшуулал	36,434,361.02	32,588,257.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,506,191.80	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>82,259,138.31</b>	<b>102,367,096.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	56,873,426.38	70,357,409.85
210202	Тэтгэмжийн даатгал	6,706,896.26	8,156,885.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,190,797.04	6,480,749.05
210204	Ажилгүйдлийн даатгал	1,226,183.54	1,569,228.86
210205	Эрүүл мэндийн даатгал	12,261,835.09	15,802,823.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>156,061,427.39</b>	<b>174,212,225.63</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,218,484.39	7,461,125.63
210302	Түлш, халаалт	141,236,863.00	157,730,900.00
210303	Цэвэр, бохир ус	8,606,080.00	9,020,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>29,533,433.00</b>	<b>30,904,124.00</b>
210502	Хоол, хүнс	29,533,433.00	30,904,124.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,271,850.00</b>	<b>25,913,337.00</b>
210604	Урсгал засвар	13,271,850.00	25,913,337.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,704,720.00</b>	<b>7,309,263.28</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,193,400.00	944,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,511,320.00	6,364,563.28
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>70,498,788.10</b>	<b>100,347,558.12</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,611,866.78	21,217,827.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,455,150.00	9,785,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,431,771.32	69,344,531.12
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>62,570,163.32</b>	<b>51,421,884.37</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>61,730,500.00</b>	<b>47,891,500.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,733,500.00	47,891,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,997,000.00	0.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	839,663.32	3,530,384.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	839,663.32	3,530,384.37
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,128,223,274.62	195,650,902.58
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,128,223,274.62	195,650,902.58

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,094,223,086.00</b>	<b>1,334,733,348.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,098,486.00</b>	<b>1,217,148.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,098,486.00</b>	<b>1,217,148.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>6,098,486.00</b>	<b>1,217,148.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,193,400.00	1,066,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,905,086.00	150,648.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,088,124,600.00</b>	<b>1,333,516,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>887,673,800.00</b>	<b>1,145,082,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	887,673,800.00	1,145,082,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>200,450,800.00</b>	<b>188,433,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	200,450,800.00	188,433,800.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,025,762,812.59</b>	<b>1,244,948,339.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,025,762,812.59</b>	<b>1,244,948,339.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>963,192,649.27</b>	<b>1,193,049,355.34</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>647,208,258.55</b>	<b>833,668,229.43</b>
210101	Үндсэн цалин	447,810,103.84	598,356,041.08
210102	Нэмэгдэл	143,923,032.38	202,723,931.35
210104	Урамшуулал	35,264,402.13	32,588,257.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,210,720.20	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>84,745,266.33</b>	<b>102,367,096.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	57,648,272.16	70,357,409.85
210202	Тэтгэмжийн даатгал	6,779,839.70	8,156,885.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,425,531.21	6,480,749.05
210204	Ажилгүйдлийн даатгал	1,353,211.22	1,569,228.86
210205	Эрүүл мэндийн даатгал	13,538,412.04	15,802,823.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>156,061,427.39</b>	<b>174,212,225.63</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,218,484.39	7,461,125.63
210302	Түлш, халаалт	141,236,863.00	157,730,900.00
210303	Цэвэр, бохир ус	8,606,080.00	9,020,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>27,915,600.00</b>	<b>33,861,424.00</b>
210502	Хоол, хүнс	27,915,600.00	33,861,424.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,038,700.00</b>	<b>10,691,190.00</b>
210604	Урсгал засвар	13,038,700.00	10,691,190.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,858,500.00</b>	<b>7,309,263.28</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,193,400.00	944,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,665,100.00	6,364,563.28
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,364,897.00</b>	<b>30,939,927.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,370,547.00	21,154,727.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,994,350.00	9,785,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>62,570,163.32</b>	<b>51,898,984.37</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>61,730,500.00</b>	<b>48,368,600.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,733,500.00	48,368,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,997,000.00	0.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>839,663.32</b>	<b>3,530,384.37</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	839,663.32	3,530,384.37
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>68,460,273.41</b>	<b>89,785,008.29</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>28,819,800.00</b>	<b>26,600,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>28,819,800.00</b>	<b>26,600,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>28,819,800.00</b>	<b>26,600,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,819,800.00	26,600,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(28,819,800.00)</b>	<b>(26,600,000.00)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>39,640,473.41</b>	<b>63,185,008.29</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	39,640,473.41
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	39,640,473.41	102,825,481.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцоонс нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	270,560,830.28	984,842,334.88	(1,255,403,165.16)	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	(1,255,403,165.16)	0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,128,223,274.62	1,128,223,274.62
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	(127,179,890.54)	1,128,223,274.62
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	(127,179,890.54)	1,128,223,274.62
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	(127,179,890.54)	1,128,223,274.62
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	195,650,902.58	195,650,902.58
20	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	270,560,830.28	984,842,334.88	68,471,012.04	1,323,874,177.20

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,375,373,500.00</b>	<b>1,268,017,955.34</b>	(107,355,544.66)	<b>92.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,375,373,500.00</b>	<b>1,268,017,955.34</b>	(107,355,544.66)	<b>92.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,319,447,000.00</b>	<b>1,219,649,355.34</b>	(99,797,644.66)	<b>92.44</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>915,113,300.00</b>	<b>833,668,229.43</b>	(81,445,070.57)	<b>91.10</b>
210101	Үндсэн цалин	642,759,100.00	598,356,041.08	(44,403,058.92)	<b>93.09</b>
210102	Нэмэгдэл	240,912,200.00	202,723,931.35	(38,188,268.65)	<b>84.15</b>
210104	Урамшуулал	31,442,000.00	32,588,257.00	1,146,257.00	<b>103.65</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>114,389,100.00</b>	<b>102,367,096.00</b>	(12,022,004.00)	<b>89.49</b>
210201	Тэтгэврийн даатгал	77,784,600.00	70,357,409.85	(7,427,190.15)	<b>90.45</b>
210202	Тэтгэмжийн даатгал	9,151,100.00	8,156,885.14	(994,214.86)	<b>89.14</b>
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,320,900.00	6,480,749.05	(840,150.95)	<b>88.52</b>
210204	Ажилгүйдлийн даатгал	1,830,200.00	1,569,228.86	(260,971.14)	<b>85.74</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	18,302,300.00	15,802,823.10	(2,499,476.90)	<b>86.34</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>177,602,500.00</b>	<b>174,212,225.63</b>	(3,390,274.37)	<b>98.09</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,518,300.00	7,461,125.63	(3,057,174.37)	<b>70.93</b>
210302	Түлш, халаалт	157,730,900.00	157,730,900.00	0.00	<b>100.00</b>
210303	Цэвэр, бохир ус	9,353,300.00	9,020,200.00	(333,100.00)	<b>96.44</b>
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>33,999,600.00</b>	<b>33,861,424.00</b>	(138,176.00)	<b>99.59</b>
210502	Хоол, хүнс	33,999,600.00	33,861,424.00	(138,176.00)	<b>99.59</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,831,300.00</b>	<b>10,691,190.00</b>	(140,110.00)	<b>98.71</b>
210604	Урсгал засвар	10,831,300.00	10,691,190.00	(140,110.00)	<b>98.71</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,768,000.00</b>	<b>7,309,263.28</b>	(1,458,736.72)	<b>83.36</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,188,500.00	944,700.00	(1,243,800.00)	<b>43.17</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,579,500.00	6,364,563.28	(214,936.72)	<b>96.73</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>58,743,200.00</b>	<b>57,539,927.00</b>	(1,203,273.00)	<b>97.95</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,723,200.00	47,754,727.00	(968,473.00)	<b>98.01</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,020,000.00	9,785,200.00	(234,800.00)	<b>97.66</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,926,500.00</b>	<b>48,368,600.00</b>	(7,557,900.00)	<b>86.49</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>55,926,500.00</b>	<b>48,368,600.00</b>	(7,557,900.00)	<b>86.49</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,926,500.00	48,368,600.00	(7,557,900.00)	<b>86.49</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,375,373,500.00</b>	<b>1,331,202,963.63</b>	(44,170,536.37)	<b>96.79</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,145,082,400.00</b>	<b>1,145,082,400.00</b>	0.00	<b>100.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,145,082,400.00	1,145,082,400.00	0.00	<b>100.00</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>188,433,800.00</b>	<b>184,903,415.63</b>	(3,530,384.37)	<b>98.13</b>
320001	Орон нутгийн төсвөөс	188,433,800.00	184,903,415.63	(3,530,384.37)	<b>98.13</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>41,857,300.00</b>	<b>1,217,148.00</b>	(40,640,152.00)	<b>2.91</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,188,500.00	1,066,500.00	(1,122,000.00)	<b>48.73</b>
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,700.00	150,648.00	(52.00)	<b>99.97</b>
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	39,518,100.00	0.00	(39,518,100.00)	<b>0.00</b>

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	39,640,473.41	39,640,473.41	1.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	102,825,481.70	102,825,481.70	1.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	37.00	34.00	(3.00)	91.89
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	0.00	100.00
630	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>381.00</b>	<b>403.00</b>	22.00	<b>105.77</b>
630001	Төрийн өмчит ЕБС	381.00	403.00	22.00	105.77

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 195,549.4 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс 154,997.8 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 222.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 40,328.8 мянган төгрөгийн зөрчилд дахин давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Аудитын явцад дараах алдаанууд илэрсэн. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан 414.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Санхүүгийн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн үр дүн 127,179.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, зэрэгцүүлсэн баланс гаргаагүй тайлан ирүүлсэн,
- 2023 оны үндсэн хөрөнгийн элэгдлийг 21,486.6 мянган төгрөгөөр дутуу тооцсон,
- Боловсролын Ерөнхий Газрын хөрөнгө оруулалтаар ирсэн 5,916.7 мянган төгрөгийн 34 нэр төрлийн ном сурах бичгийг орлого аваагүй байна.

Нийт 154,997.8 мянган төгрөгийн алдаатай тайлагнасныг УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2.1.4 “Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулав.

### 3.1 Төлбөрийн акт

Нягтлан бодогч Н.Энхцацралд тушаал шийдвэргүй, үндэслэлгүй 222.8 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон нь “Төсвийн тухай хуулийн 5.1.5-д “ хариуцлагатай байх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын бүтэц, орон тоонд батлагдаагүй ажлын байранд хавсран, орлон гүйцэтгэх тушаалаар үндсэн ажилтан нарт 2,883.4 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.2-т “батлагдсан төсвийг хэрэгжүүлэх талаар

төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Хөдөлмөрийн тухай 56 дугаар зүйлийн 56.1-т “Ажил олгогч нь ажилтантай тохиролцооноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно, 56.2-т тухайн ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно” гэсэн заалттай нийцэхгүй ба үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын анхан шатны баримтаар 14 нэр төрлийн 2,882.0 мянган төгрөгийн барилгын материалыг 2023 оны 09 дүгээр сард харилцагч байгууллагаас хүлээн авсан, тайлант сард ажлын гүйцэтгэлийг тайлагнаагүй, 2023 оны 12 дугаар сард тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д " хариуцлагатай байх", Нягтлан бодох тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

3. Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгө, бараа материалын жилийн эцсийн тооллогын тайланг хянан шалгахад дараах зөрчил ажиглагдаж байна. Үүнд жилийн эцсийн тооллогын үр дүнг 12 сарын 31-ний үлдэгдлээр тохируулдаггүй, тооллогын илтгэх хуудас болон тайланг үндсэн хөрөнгө, бараа материалын ангилал тус бүрээр дэлгэрэнгүй бодитой бичдэггүй, тооллогын хуудсыг батлагдсан маягтын дагуу бэлтгэдэггүй, санхүүгийн программаас үлдэгдлийг хуулж бичдэг, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, тооллогын комиссын тайлан мэдээг цаг хугацаанд нь тайлагнаж дүгнэлт гаргаагүй, тооллого хийсэн протокол нь тооллогын шаардлагад нийцэхгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.2-т “Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт бүртгэлээр тавих хяналтыг ерөнхий нягтлан бодогч хариуцна”, 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн тогтоосон хугацаанд явуулж, улирал жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнах”, 72.4-д “Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь НББ хөтлөх, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтад нийцэхгүй байна. гэсэн заалтуудыг зөрчсөн ба “Үнэн зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх. Үндсэн хөрөнгийн ангиллыг зөв бүртгэх, элэгдлийн тооцооллыг давтан шалгах, зөвлөмж хүргүүлэх.

4. Нөхөн хангалтын зардлын талаар

Илрүүлэлт:

Тус сургууль сургалтын орчин болон цахим орчныг бүрдүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, компьютер түүний дагалдах хэрэгслийг худалдан авах, нөхөн хангалтын зардлыг зарцуулахдаа ажлын хэсэг байгуулаагүй, төлөвлөгөө гаргаж хэлэлцүүлээгүй 26,600.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль 8 дугаар зүйлийн 8.2 “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 8.13 “Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт 7.7.4. “Энэ

аргачлалын 7.7.3-т заасны хүрээнд төсвийн шууд захирагч нь тухайн сургалтын байгууллагад хуваарилагдах тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлаар шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах хэрэгцээг эрэмбэлж, үе шаттай шийдвэрлэх төлөвлөгөө баталж, шийдвэрлэх”, 7.7.6.”Эрх бүхий байгууллагын холбогдох шийдвэрийн дагуу нөхөн хангалтын хүрээнд шаардлагатай сургалтын тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран ерөнхий гэрээний аргаар хийх” гэсэн заалт, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 3.3 дахь заалт, "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 3.1 дэх заалт, "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх заавар, аргачлал"-ын 2.2.5 дах заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх. Сургалтын тоног, төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг зарцуулах, худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, журам зааврын дагуу хийж байх зөвлөмж хүргүүлэх.

3. Хөрөнгийн элэгдэл тооцох талаар

Илрүүлэлт:

Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 7,963.0 мянган төгрөгийн зүлэгжүүлсэн талбай, мод бут сөөгт элэгдэл тооцсон байгаа нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 сарын 18 өдрийн 271 тоот тогтоолын 4.1.3 “Энэ журмын 4.1.1-д заасан хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлийг албан ёсоор авч үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгана”, Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 207 дугаар тушаалын 4.39 “Мод суулгац Биологийн хөрөнгийг НББОУС –ийн үндсэн хөрөнгө-д бүртгэх шалгуурыг хангасан тохиолдолд дахин үнэлж тайланд тусгана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх. Дээрхи хөрөнгүүдийг дахин үнэлж тайланд тусгах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, журам зааврын дагуу хийх зөвлөмж хүргүүлэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланд залруулга хийсэн	1	414.7					1	414.7				
Санхүүгийн тайланд залруулга хийсэн	1	127,179.9					1	127,179.9				
Элэгдэлийг дахин тооцоолсон.	1	21,486.6					1	21,486.6				
Ном сурах бичгийг орлого аваагүй	1	5,916.7					1	5,916.7				
	4	154,997.82	-	-	-	-	4	154,997.82	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант сард ажлын гүйцэтгэл гарсан ажил гүйлгээг тайлагнаагүй	1	2,882.0					1	2,882.0				
Тооллогын үр дүнг дүгнээгүй, тайлан мэдээг бүрэн гаргаагүй	1	-					1	-				
Зүлэгжүүлсэн талбай, мод бут сөөгт элэгдэл тооцсон.	1	7,963.4					1	7,963.4				
Ажилтан нарт нэмэгдэл цалин олгосон	1	2,883.4					1	2,883.4				
Балансын урамшуулалыг үндэслэлгүй олгосон	1	222.8	1	222.8								
Нөхөн хангалтын зардалыг зарцуулах	1	26,600.0					1	26,600.0				
Нийт дүн	6	40,551.6	1	222.8			5	40,328.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаагүй, шилэн дансаны цахим мэдээлэлд оруулаагүй, хамтран ажиллах гэрээ, худалан авах гэрээнүүд дүгнэж акт үйлдээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	0					1	0
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад орлогын 392,654.1 мянган төгрөгийн 28 гүйлгээ, 6.4.8-д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 2,603.0 мянган төгрөгийн 1 шийдвэр тус тус мэдээлээгүй байна.	1	149,048.10					1	149,048.10
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>149,048.10</b>					<b>2</b>	<b>149,048.10</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>149,048.10</b>					<b>2</b>	<b>149,048.10</b>